

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ  
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,  
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

**Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчилсэн найруулга хэлбэрээр 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаар баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна.

Тус хуулийг шинэчилэн батлах болсон хууль зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд дөрвөн чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулсны нэг нь нутгийн удирдлагатай холбоотой өөрчлөлт орсонтой шууд холбоотой юм. Орон нутагт төсөв, санхүүгийн тодорхой эрх мэдэл өгч, өөрөө бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг судлаачид тэмдэглэдэг. Тиймээс ийм нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон орон нутгийн удирдлагыг холих биш, хослуулах, Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг бодитой хэрэгжүүлэх үүднээс Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсан.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах, улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах, нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх зэрэг зарчмыг баримтлахаар хуульд заасан.

Энэ хүрээнд сумын иргэдийн төлөөлөгчдийн тодорхой хувь нь төрийн захиргааны албан хаагч байхаар хуульд заасан байна. Тодруулбал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.” гэж заасан нь хууль зүйн асуудал дагуулж байна.

Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан бөгөөд зөвхөн сумын иргэдийн төлөөлөгчдийн тодорхой хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болохоор заасан нь хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаж байна.

Түүнчлэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй.” гэж зааснаар шат шатны иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал нь тухайн орон нутгийн нийт иргэд, сонгогчдийн төлөөллийн байгууллага юм.

Энэ нь иргэн бүр өөрийн төлөөллийн байгууллагаараа дамжуулан орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг бодитой хангахад чиглэсэн зохицуулалт юм. Гэтэл дан ганц сумын иргэдийн төлөөлөгч нарын тодорхой хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болохоор хуульд заасан бөгөөд бусад шатны төлөөллийн байгууллага болох аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгч нарын тодорхой хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болохгүй гэж хуульчилсан явдал нь хуулиар ялгамжтай байдлыг бий болгож, Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчим зөрчигдөж байна.

Мөн аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгч нар нь тухайн орон нутгийн нийт иргэд, сонгогчдийн төлөөлөл бөгөөд иргэд санал, хүсэлтээ төлөөлөгчдөөрөө дамжуулан нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг бодитой хангах буюу эрх зүйн орчны хувьд адил юм.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг хуульчилж өгсөн атлаа шат, шатны иргэдийн төлөөлөгч нарыг хуульд заасан үндэслэл, журам нэрийн дор эрх зүйн байдлын хувьд ялгамжтай байдал үүсгэж байгаа нь төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдах ёсны үйл ажиллагаанд оролцох иргэдийн эрх, оролцоог ялгаатай түвшинд хүргэж байна.

Иймд Улсын Их хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Монгол Улсын Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.” гэж заасныг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тавин хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.” гэж хамрах хүрээг өргөжүүлж, хувь хэмжээг нэмэгдүүлэх байдлаар өөрчлөн найруулж, иргэд өөрсдийн төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн өөрөө удирдах үйл ажиллагаанд оролцох, эс оролцох эрх бодитой хангагдах эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа.

## **УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

### **Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал.**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй болно.

### **Хоёр. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан.**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжиж нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах эрх зүйн шинэ орчин бүрдэж эхэлсэн боловч иргэд, оршин суугчдын шилжилт хөдөлгөөн, ажлын өндөр бүтээмж бүхий хөдөлмөрийн насны хүмүүсийн гадаад улсад хөдөлмөр эрхлэх явдал эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж өссөн хэвээр байна.

Үүнтэй холбоотой аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, цаашлаад төлөөлөгчөөр ажиллах хүсэл, сонирхолтой иргэдийн тоо буурсан, одоо ажиллаж байгаа иргэдийн Төлөөлөгч нар төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусмагц дахин сонгогдохоор нэр дэвшихгүй байх, мөн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө төлөөлөгчөөс огцрох хүсэлтэй байгаа тухайгаа илэрхийлэх явдал цөөнгүй гараад байна. Энэ нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь төлөөлөгчөөр ажиллах нийгмийн баталгаа, хөшүүрэг тодорхойгүй байдагтай холбоотой юм.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч төдийгүй Улсын хэмжээнд ажиллах боловсон хүчний тоо, хэмжээ эрс багасч төрийн бүх шатны байгууллага, мөн түүнчлэн төсвийн болон орон нутгийн өмчит компани, аж ахуй нэгж байгууллагад ажиллах боловсон хүчний дутагдал бодитой үүсч байгаа бөгөөд уг асуудлыг бодлогын түвшинд цогцоор нь шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ажиллах боловсон хүчний дутагдлыг нөхөх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харъяалагдаж буй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын тодорхой хувийг төрийн захиргааны албан хаагч байхаар хуульд өөрчлөлт оруулж, Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын шаардлагыг хангах нь нийгэм, хууль зүйн ач холбогдолтой байна.

Иймд энэхүү хууль нь цаг үеэ олсон, дээрх олон харилцааг зохицуулахад чиглэсэн чухал шаардлагатай хуулийн төсөл болсон байна.

### **Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зэрэг, сөрөг талыг харьцуулсан байдал**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зэрэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж, дараах дүгнэлтийг гаргалаа:

| Хувилбар                             | Зорилгод хүрэх байдал            | Зардал, үр өгөөжийн харьцаа |
|--------------------------------------|----------------------------------|-----------------------------|
| Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой | Нэмэлт зардал шаардагдахгүй |

**Тав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариуцлах замаар дүгнэлтийг гаргалаа.

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө                                   | Холбогдох асуулт                                                                                                                                                                                 | Хариулт |      | Тайлбар                        |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх                                                                                                                                                         |         |      |                                |
|                                                    | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх                                                                                                                                                       | Тийм    |      | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                    | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх                                                                                                                         |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                    | 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм    |      | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                    | 1.2.Оролцоог хангах                                                                                                                                                                              |         |      |                                |
|                                                    | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх                                                                | Тийм    |      | Шудрага ёсны зарчимд нийцсэн   |
|                                                    | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг                                                                                                                                          | Тийм    |      | Шудрага ёсны зарчимд нийцсэн   |

|                                                       |                                                                                                                                                                  |      |      |                                                                              |
|-------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|------------------------------------------------------------------------------|
|                                                       | сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх                                                                               |      |      |                                                                              |
|                                                       | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага                                                                                                            |      |      |                                                                              |
|                                                       | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх                                                  | Тийм |      | Шударга, тэгш эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. |
|                                                       | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм |      | Шударга, тэгш эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. |
|                                                       | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх                                                                                                  |      | Үгүй | Энэ асуудалтай холбоогүй                                                     |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх                                                              |      | Үгүй | Хуулийн зорилго шудрага ёсонд нийцсэн.                                       |
|                                                       | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх                                                                                                                         |      | Үгүй | Шаардлагагүй                                                                 |
| 3.Эрх агуулагч[8]                                     | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх                                                                              |      | Үгүй | Шаардлагагүй                                                                 |
|                                                       | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх                                                                                                    |      | Үгүй | Шаардлагагүй                                                                 |
|                                                       | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх                                |      | Үгүй | Шаардлагагүй                                                                 |

|                                                                  |                                                                                                                                                                                                    |      |      |                                |
|------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|--------------------------------|
|                                                                  | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) |      | Үгүй | Шаардлагагүй                   |
| 4.Үүрэг хүлээгч[9]                                               | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх                                                                                                                                                            |      | Үгүй | Шаардлагагүй                   |
| 5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх                                                                                                                                                       | Тийм |      | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                  | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх                                                                                                          | Тийм |      | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

Хүснэгт 2

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө                        | Холбогдох асуулт                                                                                                           | Хариулт |      | Тайлбар                        |
|-----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх        |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                         |                                                                                                                            |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                         | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                         | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх                 |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                                                                                    |                                                                                                                               |  |      |                                   |
|------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|-----------------------------------|
| 2.Дотоодын<br>зах зээлийн<br>өрсөлдөх<br>чадвар болон<br>тогтвортой<br>байдал      | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах<br>боломжийг бууруулах эсэх                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний<br>улмаас үнийн хөөрөгдлийг бий<br>болгох эсэх                                                 |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 2.3.Зах зээлд шинээр орж ирж<br>байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл,<br>хүндрэл бий болгох эсэх                                   |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 2.4.Зах зээлд шинээр монополийг<br>бий болгох эсэх                                                                            |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
| 3.Аж ахуйн<br>нэгжийн<br>үйлдвэрлэлийн<br>болон<br>захиргааны<br>зардал            | 3.1.Зохицуулалтын хувилбарыг<br>хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид<br>шинээр зардал үүсэх эсэх                                    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж<br>авахад нөлөө үзүүлэх эсэх                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 3.3.Зах зээлээс тодорхой бараа<br>бүтээгдэхүүнийг худалдан авахад<br>хүргэх эсэх                                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 3.4.Бараа бүтээгдэхүүний<br>борлуулалтад ямар нэг хязгаарлалт,<br>эсхүл хориг тавих эсэх                                      |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|                                                                                    | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл<br>ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх                                                                |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
| 4.Мэдээлэх<br>үүргийн<br>улмаас үүсч<br>байгаа<br>захиргааны<br>зардлын<br>ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны<br>шинж чанартай нэмэлт зардал<br>(Тухайлбал, мэдээлэх, тайлан<br>гаргах г.м) бий болгох эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |

|                                     |                                                                                                               |  |      |                                |
|-------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|--------------------------------|
| 5.Өмчлөх эрх                        | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх                            |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх                                   |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх   |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв  | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх                                                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх                                        |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх                                                                     |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                     | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд     | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх                         |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                                 |                                                                                                                  |      |      |                                  |
|---------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----------------------------------|
|                                 | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх               |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
|                                 | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх                                                |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх                                                                              |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
|                                 | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
|                                 | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх                                                |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд  | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх                                        |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
|                                 | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх                        |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
|                                 | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх                                                                                       |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй   |
| 11.Олон улсын харилцаа          | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх                                                         | Тийм |      | Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй |

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө                               | Холбогдох асуулт                                                                             | Хариулт |      | Тайлбар                        |
|------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх                                                         |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх                            |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх    |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх                           |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх              | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх                                                    |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх                           |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх                                |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх                                                        |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                                                                                  |                                                                                                                                                        |  |      |                                |
|----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|--------------------------------|
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал                                    | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх                                                                                                 |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх                                                                                                             |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх                                                                                                    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх                                                                                        |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх                                                                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх                                                                                 |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх                                                                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал                                             | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх                                                                 |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                                                  | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх                    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                                                      |                                                                                                                                                             |  |      |                                |
|------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|--------------------------------|
|                                                      | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх                                                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх                                                                                                   |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх                                                                                                    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх                                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх                                                                                    |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал                | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх                                                                                      |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх                                                                                                             |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх                                                                                                             |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                                      | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх                                                                                         |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|        |                                                                                          |  |      |                                |
|--------|------------------------------------------------------------------------------------------|--|------|--------------------------------|
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх                                          |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|        | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|        | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх                              |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө                | Холбогдох асуулт                                                        | Хариулт |      | Тайлбар                        |
|---------------------------------|-------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------|
| 1.Агаар                         | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч   | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх    |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                 | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх                             |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                 | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх                         |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                 | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх              |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх                                |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                 | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх    |         | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                                        |                                                                                                                      |  |      |                                |
|----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|--------------------------------|
|                                        | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх                                                               |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх                                                          |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Усны нөөц                            | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх                                          |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх                                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх                                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Хөрсний бохирдол                     | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх                                                                           |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх                                                      |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Газрын ашиглалт                      | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх                                                                         |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх                                                                                  |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|                                        | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх                                             |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

|                     |                                                                         |  |      |                                   |
|---------------------|-------------------------------------------------------------------------|--|------|-----------------------------------|
| байгалийн<br>баялаг | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй<br>байгалийн баялгийн ашиглалт<br>нэмэгдэх эсэх |  | Үгүй | Ямар нэгэн сөрөг<br>нөлөө байхгүй |
|---------------------|-------------------------------------------------------------------------|--|------|-----------------------------------|

### **Зургаа. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

6.1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалыг удирдлага болгов.

6.2. Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийсэн. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн хувьд хуулийн төслийн үзэл баримтлал болон энэхүү хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомжтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байдлаар илэрч байна.

Хуулийн төсөлд төсвөөс нэмэлт зардал гарахгүй. Монгол улсын засаг захиргааны шат нэгжид ажиглаж буй иргэдийн Төлөөлөгч нар ижил тэгш, хууль зүйн боломжоор хангагдснаар иргэдийн Төлөөлөгч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхол бодитой хангагдахын зэрэгцээ иргэдийн нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох, эс оролцох эрх аливаа хязгаарлалтгүй хэрэгжихэд энэхүү хуулийн зохицуулалт эерэг үр дагавар авчрах юм.

Улсын Их хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт өөрчлөлт оруулснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын эрх зүйн байдал ижил тэгш түвшинд хүрэх, төлөөлөгч нарын тодорхой хувь нь төрийн захиргааны албан хаагч болсноор төлөөлөгч нарын үйл ажиллагааны баталгаа хангагдах эрх зүйн үндэслэл бүрдэх юм.

Иймд хуулийн төсөл дэмжигдэх болон хэрэгжих бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

---oOo---